

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА


Л. ГАНБОЛД
(Гарын үсэг)

ГҮЙЦЭТГЭГЧ:

“УРГАМАЛЫН ДАЛАЙ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ


Ц. ТҮМЭНБАЯР
(Гарын үсэг)

**БАГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД СУМЫН
ХҮҮХДИЙН ПАРКЫН ТОГЛООМЫН ШИНЭЧЛЭЛИЙН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар № ЗГХЭГ/202002008/1.3.9-Б/9

Хөвсгөл аймаг

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг талаас *Хөвсгөл аймгийн Засаг дарга Л. ГАНБОЛД* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, Хоймор оффис 12 давхар 1208 тоот “Ургамалын далай” ХХК-ийн захирал Ц. Түмэнбаяр* (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1.1 “Иргэний хууль”, “Барилгын тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2 Захиалагч нь *Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд сумын хүүхдийн паркийн тоглоомын шинэчлэлийн ажил ЗГХЭГ/202002008/1.3.9-Б/9-г* (цаашид “ажил” гэх) **49,528,219 (Дөчин есөн сая таван зуун хорин найман мянга хоёр зуун арван есөн)** төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

1.3 Гэрээний нийт дүн: **49,528,219 (Дөчин есөн сая таван зуун хорин найман мянга хоёр зуун арван есөн)** төгрөг. Үүнээс :

Санхүүжилтийн эх үүсвэр: **Улсын төсвийн хөрөнгө оруулалт**

2020 онд: **49,528,219 (Дөчин есөн сая таван зуун хорин найман мянга хоёр зуун арван есөн)** төгрөг;

1.4 Гүйцэтгэгч нь *Хөвсгөл аймгийн Мөрөн суманд байршилтай Хүүхдийн паркийн тоглоомын шинэчлэлийн ажлыг* 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдөр эхэлж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр ашиглалтад оруулна.

1.5 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний бичиг баримт” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендер;

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;


Техникийн тодорхойлолт;


Зураг;

Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь¹;

Санхүүжилтийн хуваарь;

¹ Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж солино.

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 

Ажил гүйцэтгэх хуваарь.

Ажил гүйцэтгэх тухай гүйцэтгэгчийн аргачлал, ажлын хөтөлбөр.

Бусад шаардлагатай баримт бичиг²;

Гүйцэтгэлийн баталгаа:

Голомт банкинд 2020-06-09 өдрийн 140OLCPF200032 дугаар бүхий 2,476,420 төгрөгийн.

1.6. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

1.7 Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, хариуцлагыг хүлээнэ.

1.8 Гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн баталгааг ажил дууссан тухай мэдэгдэл (Улсын комиссын акт) гарснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байлгана. Гэрээт ажил дуусаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөхийг хориглох бөгөөд баталгаа чөлөөлсөн нөхцөлд захиалагчийн шийдвэрээр гэрээг цуцлана.

1.9 Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сүүлийн санхүүжилтээс суутган тооцож 1 жилийн хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн дансанд байршуулна.

1.10 Ажлыг Улсын комисс болон захиалагчийн ажлын хэсэгт хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацааны 1 жил болон Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэгт заасан 3 жилийн хугацаанд чанаргүй болон дутуу гүйцэтгэлийн улмаас барилга байгууламж, тоног төхөөрөмж, материал бүтээцэд гарсан зөрчил, гологдлыг засварлах шаардлага гарсан тохиолдолд захиалагч нь гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэнэ. Гүйцэтгэгч нь захиалагчийн хүсэлтийн дагуу барилгын ажлын зөрчил гологдлыг арилгах үүрэг хүлээнэ.

1.11 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг бүрэн, чанартай гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

1.12 Гүйцэтгэгч нь 1.10 дахь хэсэгт заасан засварын ажлыг мэдэгдэл авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гүйцэтгээгүй тохиолдолд захиалагч энэхүү гэрээний 1.9 дахь хэсэгт заасан барьцаа хөрөнгөөс гарган засварын ажлыг бусад этгээдээр гүйцэтгүүлэх буюу үүргээ гүйцэтгээгүй гүйцэтгэгчийг "Тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл"-д бүртгүүлэхээр холбогдох байгууллагад хандана.

1.13 Барилгын ажлын гэрээний төлбөрийг санхүүжилтийн хуваарийн дагуу гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжүүлэх бөгөөд гэрээний төлбөрийн үлдэгдэл 10-аас доошгүй хувийн санхүүжилтийг барилгын ажлыг дуусган улсын комисст хүлээлгэн өгч, гэрээ дүгнүүлсний дараа олгоно.

1.14 Барилгын ажил нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөхгүй.

1.15 Зайлшгүй шаардлагаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож гэрээний үнэ, ажлын тоо хэмжээнээс бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж болох бөгөөд тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болсонд тооцно.

1.16 Гүйцэтгэгчид олгох гэрээний төлбөрөөс дараах зардлуудыг захиалагчийн холбогдох дансанд суутгана.

- Зураг төсөв, инженер геологи, эксперт үнэ: **0,0 (тэг)** төгрөг
- Захиалагчийн хяналтын зардал: **328,846 (Гурван зуун хорин найман мянга найман зуун дөчин зургаан төгрөг)** төгрөг
- Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал: **164,423 (Нэг зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун хорин гурван)** төгрөг

² Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Захиалагчийг төлөөлж: _____

Гүйцэтгэгчийг төлөөлж: _____

- Магадлашгүй ажил: 328,846 (Гурван зуун хорин найман мянга найман зуун дөчин зургаан төгрөг) төгрөг

Зураг төсөвт тусгагдаагүй зайлшгүй хийгдэх болзошгүй ажлын зардлыг магадлашгүй ажлын зардлаас санхүүжүүлж болно.

1.17 Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол аригдах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөр төлөх болон чанарын баталгааны барьцаа хөрөнгийг гүйцэтгэгчид чөлөөлөн олгох үүрэг хүлээнэ.

1.18 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

1.19 Талуудын санаачлагаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг дүгнэж хохиролыг тооцож хохирол тооцсон мэдэгдлийг хариуцагч талд хүргүүлж, гэм буруутай тал хохиролыг барагдуулна.

ХОЁР.ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

2.1 Гүйцэтгэгч нь ажлын тендерт өөрийн ирүүлсэн баримт бичиг, ажлын гүйцэтгэлийн талаар бүрдүүлж өгсөн зураг, төсөв, баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцна.

2.2 Талууд бие биенийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

2.3 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй. Шилжүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаврыг шилжүүлсэн тал өөрөө хариуцна.

2.4 Гүйцэтгэгч нь захиалагчаас хүлээн авсан ажлын талбай болон барилга байгууламж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.

2.5 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг захиалагчийн санаачлагаар болон гүйцэтгэгчийн хүсэлтээр цуцалсан тохиолдолд гүйцэтгэгчээс гаргасан "гүйцэтгэлийн баталгаа"-г захиалагчийн өмчлөлд "үл маргах журам"-аар шилжүүлэх үүргийг баталгаа гаргагч банк хариуцана..

2.6 Гэрээнд хамаарах хууль тогтоомжийн холбогдох заалт болон энэ гэрээний ерөнхий нөхцөл, захиалагч, гүйцэтгэгчийн эрх, үүрэг, тусгай нөхцөл, бусад нөхцлийг зөрчсөн тал "Барилгын тухай хууль"-ийн 50 дугаар зүйл, "Иргэний хууль"-ийн 222 дугаар зүйлийн 222.4, 223 дугаар зүйлийн 223.1, 223.2, 225 дугаар зүйлийн 225.5, 227 дугаар зүйлийн 227.1, 227.3, 227.5, 229 дүгээр зүйлийн 229.1, 230 дугаар зүйлийн 230.1, 230.2, 231 дүгээр зүйлийн 231.1.1, 231.1.3, 232 дугаар зүйлийн 232.6, 234 дүгээр зүйлийн 234.4, 249 дүгээр зүйлийн 249.1, 349 дүгээр зүйлийн 349.1, 355 дугаар зүйлийн 355.6, 457 дугаар зүйлийн 457.10 дахь хэсгүүдэд заасан хариуцлагыг хүлээнэ.

2.7 Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөж чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГУРАВ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ.

Гэрээг дор дурьдсан үндэслэлээр цуцална. Үүнд:

3.1 "Иргэний хууль"-ийн 221 дүгээр зүйлийн 221.3, 225 дугаар зүйлийн 225.3, 225.7, 240 дүгээр зүйлийн 240.1.2, 249 дүгээр зүйлийн 249.1, 356 дугаар зүйлийн 356.1, 356.2, 356.3 дахь хэсгүүд энэ гэрээний ерөнхий нөхцөлийн 56.2 дахь хэсэг, гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 56.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон

3.2 Захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээг сунгах бололцоогүй болсон эсхүл ажлын үе шатны хуваарьт заасан ажил хийгдээгүй, чанаргүй гүйцэтгэл гарсан, барилгын ажилын гүйцэтгэлийг хийхдээ мэргэжлийн алдаа гаргасан захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтыг хангахааргүй материалыг ашигласан зэрэг нь эрх бүхий албан тушаалтны дүгнэлтээр тогтоогдсон

3.3 Гүйцэтгэгч гэрээний үүрэг, захиалагчийн болон эрх бүхий хяналт шалгалтын байгууллагын дүгнэлт албан шаардлагыг биелүүлээгүй, гэрээний үүргээ зөрчсөн, эсхүл захиалагчаас хүлээн авсан ажлын талбай, барилга байгууламжийг учирч болох эрсдлээс хамгаалах, зүй зохистой ашиглах арга хэмжээ аваагүй, гэрээний үүргээсээ өөрөө татгалзсан зэрэг тохиолдолдлууд,

Захиалагчийг төлөөлж: _____



Гүйцэтгэгчийг төлөөлж: _____



3.4 Гэрээ гүйцэтгэгчийн хүсэлтээр цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч дараах хариуцлагыг хүлээнэ. Үүнд:
1. Гүйцэтгэгчийг “Тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлэх хүсэлтийг захиалагчаас санаачлан холбогдох байгууллагад хүргүүлнэ.
2. Гэрээ цуцалсны улмаас захиалагчид учирсан хохирол (Санхүүжилт татагдах, тендер зарлах, гэрээ байгуулах, ажлын талбайг чөлөөлөх, хүлээлгэн өгснөөс үүсэх зардал, ирээдүйд олохоор тооцон үр ашиг)-ыг гүйцэтгэгч хариуцан барагдуулна.


ДӨРӨВ. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

4.1. Гэрээг 5 хувь үйлдэж захиалагч тал гурав, гүйцэтгэгч тал 2 хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдөр гэрээ хүчин төгөлдөр болно.
4.2 Сангийн сайдын 2012 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 81 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “ажил худалдан авах ажиллагаа”-ны тендерийн жишиг баримт бичгийн гэрээний ерөнхий нөхцөл, гүйцэтгэлийн баталгаа болон энэ гэрээний 1.5 дахь хэсэгт заасан баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.
4.3 Энэхүү гэрээний нөхцөлд гэрээнд заасан ажлын тоо хэмжээ, үнэ өөрчлөхөөс бусад асуудлаар нэмэлт гэрээ байгуулж болох бөгөөд уг нэмэлт гэрээ нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.
4.4 Энэхүү гэрээ нь гэрээг цуцалснаас бусад тохиолдолд “Барилгын тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг заасан хугацаа дуусах өдөр хүртэл хүчинтэй байна.

ТАВ. ГЭРЭЭ ДҮГНЭХ

5.1 Захиалагчийн төслийн баг болон гүйцэтгэгч байгууллага хамтран ажил гүйцэтгэх гэрээг дүгнэнэ.
5.2 Барилга угсралтын ажлын үндсэн гэрээ болон нэмэлт гэрээг тухайн үе шатанд хийгдсэн ажлын гүйцэтгэл, гэрээний бусад нөхцлийг үндэслэн дүгнэнэ.
5.3 Барилгын ажлын гүйцэтгэл бүрэн дууссан тохиолдолд төслийн баг, гүйцэтгэгч, ашиглагч, зохиогч хамтран уг барилга багууламжид үзлэг шалгалт хийн техник хяналтын нэгдсэн дүгнэлт, байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс ажиллуулах тухай мэдэгдлийг аймгийн Засаг даргад хүргүүлэх ба аймгийн Засаг дарга барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс томилох шийдвэр гаргана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГИЙН ГАЗРЫН ДАРГА

Х.ГАН-ОЧИР
Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын “А” байр
Утасны дугаар: 70388699

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА


Б.БОЛД
Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын “А” байр
Утасны дугаар: 70388849

ХЯНАСАН:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ
ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Г.ГАНДЭЛГЭР
Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын “А” байр
Утасны дугаар:
70382751,

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“УРГАМАЛЫН ДАЛАЙ” ХХК-
ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Б.БАТСАЙХАН

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
9-р хороо, Хоймор оффис 12 давхар
1208 тоот
Утас: 70110085, 95955585
Харилцагч банкны нэр: Голомтбанк
Дансны дугаар: 1105065510
Регистрийн дугаар: 5340055

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 

НЭГ. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ


Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн тодорхойлж гаргасан байна. Захиалагч холбогдох хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.


Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно:

Гэрээний ерөнхий нөхцлийн дугаар	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд сумын хүүхдийн паркийн тоглоомын шинэчлэлийн ажил гүйцэтгэх гэрээ
55.0	Ашиглалт, засвар үйлчилгээний хуваарь
ГЕН 8.0	Бусад гүйцэтгэгчдийн хуваарь
ГЕН 9.0	Голлох мэргэжилтний хуваарь
ГЕН 14.0	Ажлын талбайн судалгааны тайлан
ГЕН 34.0	Ажлын үе шатны хуваарь


Захиалагч, гүйцэтгэгч гэрээний ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөлийн дараах заалтуудыг мөрдөнө. Ерөнхий нөхцөлийн холбогдох заалт тусгай нөхцөлийн заалттай зөрчилдвөл тусгай нөхцөлд заасныг баримтална.


Гэрээний ерөнхий нөхцлийн дугаар	Гэрээний тусгай нөхцлийн заалтууд
ГЕН 1.1	Захиалагч: Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөвсгөл, Мөрөн сум, 8-р баг, Аймгийн ЗДТГ-ын байр
ГЕН 1.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар нь Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд сумын хүүхдийн паркийн тоглоомын шинэчлэлийн ажил гүйцэтгэх гэрээ ЗГХЭГ/202002008/1.3.9-Б/9
ГЕН 1.1	Төслийн менежер:
ГЕН 1.1	Ажил нь нь Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд сумын хүүхдийн паркийн тоглоомын шинэчлэлийн ажлын захиалагчийн боловсруулсан техникийн тодорхойлолтод заагдсан ажилбарууд -аас бүрдэнэ.
ГЕН 1.1	Ажил эхлэх өдөр 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдөр
ГЕН 1.1	Ажлын талбай нь Хөвсгөл аймгийн Мөрөн сумын нутаг дэвсгэрт -д байрших ба техникийн тодорхойлолтод зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.0	Гэрээний баримт бичгүүд нь [Монгол] хэл дээр байна.
ГЕН 3.0	Гэрээнд Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.
ГЕН 4.1	Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
ГЕН 6.1	Талуудын гэрээний ерөнхий нөхцөлд холбогдох харилцаа нь зөвхөн бичгээр харилцсан тохиолдолд хүчинтэй байна. Бичгээр гаргасан мэдэгдэл нь нөгөө тал хүлээн авснаар хүчинтэй болно.
ЕН 11	11.1 Ажил эхлэх өдрөөс зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гарах өдөр хүртэл хугацаанд захиалагч дор дурдсан эрсдлийг хүлээнэ: а) Дараах зүйлээс шалтгаалан хүн бэртэх, нас барах, эсхүл эд хөрөнгө алдагдах, эвдэрч гэмтсэнээс үүсэх (ажил, байгууламж, материал, тоног төхөөрөмж үл хамаарна) эрсдэл: 1) ажлын талбайг гэрээний дагуу ашиглах, эсхүл эзэмших явцад урьдчилан сэргийлэх боломжгүй; 2) захиалагч, эсхүл түүний хөлслөн ажиллуулж буй гүйцэтгэгчээс бусад этгээдийн хариуцлагагүй, хууль ёсны үүргээ зөрчсөн, эсхүл түүнд олгогдсон эрхийг буруу эдэлсний улмаас үүдэн гарсан (б) Захиалагчийн гэм буруугаас, эсхүл захиалагчийн зураг төслийн алдаанаас, эсхүл гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас ажил, байгууламж, материал болон тоног төхөөрөмж гэмтэх эрсдэл. 11.2. Ажил дууссан өдрөөс зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гарсан өдөр хүртэл хугацаанд ажил, байгууламж, материал алдагдах, эвдэрч гэмтэх эрсдэл нь дор дурдсанаас бусад тохиолдолд захиалагчийн хүлээх эрсдэл болно:

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 

	(a) ажил дууссан өдөр илэрсэн зөрчил, гологдол; (б) захиалагчийн хүлээх эрсдэлд хамаарахгүй бөгөөд ажил дууссан өдрөөс өмнө бий болсон зөрчил, гологдол; (в) ажил дууссан өдрөөс хойш ажлын талбай дээр гүйцэтгэгчийн явуулсан үйл ажиллагаанаас үүдсэн зөрчил, гологдол.
ГЕН 12.1	Ажил эхлэх өдрөөс зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргасан өдөр хүртэлх хугацаанд хүн бэртэх, нас барах, түүнчлэн эд хөрөнгө (ажил, байгууламж, материалыг оролцуулах бөгөөд эдгээрээр хязгаарлахгүй) алдагдах, эвдэрч гэмтэхээс үүдэн гарсан бөгөөд захиалагчийн хүлээх эрсдлээс бусад эрсдлийг гүйцэтгэгч хүлээнэ.
ГЕН 13.2	Гүйцэтгэгч нь ажлын талбай, тоног төхөөрөмж, ажиллах хүчнийг даатгалд хамруулж болно. Даатгал хийлгэсэн тохиолдолд даатгалын гэрээ, гэрчилгээг ажил эхлэх өдрөөс өмнө төслийн менежерт хүргүүлж батлуулна. Даатгалыг 13.1-д заасан тохиолдлоос үүдэн гарсан хохирлыг арилгахад зориулж гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр хийлгэнэ.
ГЕН 18	18.1 Гүйцэтгэгч санал болгож буй туслах ажлын техникийн тодорхойлолт, зургийг уг ажил эхлэх хугацаанаас 10-аас доошгүй хоногийн өмнө гарган төслийн менежерт хүргүүлэх ба эдгээр нь ажлын техникийн тодорхойлолт, зурагт нийцсэн тохиолдолд төслийн менежер түүнийг батална. 18.2 Гүйцэтгэгч нь туслах ажлын зураг төслийг хариуцна. 18.3 Төслийн менежер туслах ажлын зураг төслийг батлах нь туслах ажлын зураг төсөлтэй холбоотой гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй 18.4 Шаардлагатай тохиолдолд гүйцэтгэгч туслах ажлын зураг төсөлд холбогдох байгууллагын зөвшөөрөл авна. 18.5 Гүйцэтгэгчийн бэлтгэсэн түр болон үндсэн ажилд ашиглах бүх зургийг ажил эхлэхээс өмнө төслийн менежер батална.
ГЕН 21	Ажлын талбайг ашиглуулж эхлэх өдөр 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдөр, ажлын талбайг ашиглагч хүлээлгэн өгнө.
ГЕН 25	Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, талбайн зохион байгуулалтын зураглал болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш [20] хоногийн дотор төслийн менежерт хүргүүлж батлуулна.
ГЕН 25	Ажлын хөтөлбөрийг [30] хоног тутам тодотгох бөгөөд ажлын тодотгосон хөтөлбөрт үйл ажиллагаа бүрийн явц, үр дүн, тэдгээрийн үлдэж буй ажлыг гүйцэтгэх хугацаанд үзүүлэх нөлөө болон үйл ажиллагааны дараалалд оруулсан аливаа өөрчлөлтийг тусгана.
ГЕН 25	Тодотгосон ажлын хөтөлбөрийг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд суутгах үнийн дүн нь: Тодотгосон ажлын хөтөлбөрийг хугацаа хоцроож ирүүлсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,01 хувьтай тэнцэх алдангийг захиалагч суутгана.
ГЕН 25	Захиалагчийн томилсон төслийн баг ажлын үе шатны хяналтыг хийж, захиалагчийн техник хяналтын нэгдсэн дүгнэлт гаргаж, гэрээг дүгнэнэ. Төслийн менежер, аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөөлөл, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас төслийн багт томилогдсон хяналтын инженер, гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл, зураг төсөл зохиогч, аймгийн онцгой байдлын газрын холбогдох улсын байцаагч зэрэг албан тушаалтнууд ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг, барилгын ажилд хэрэглэсэн барилгын материалын техникийн тодорхойлолт, ажлын гүйцэтгэл зэрэг баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулна.
ГЕН 26	Ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, урьдчилан төлөвлөх боломжгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд төслийн багийн шийдвэрийг үндэслэн Төслийн менежер ажлын аль нэг үйл ажиллагааны эхлэл, эсхүл явцыг хойшлуулах зааварчилгааг гүйцэтгэгчид өгч гэрээний хугацааг сунгах эрхтэй. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас үе шатны хуваарьт заасан ажил хойшилсон тохиолдолд гэрээний хугацааг сунгаж өөрчлөхийг хориглоно.
ГЕН 28	Төслийн менежер нь гэрээний ажлын үе шатны хуваарьт заасны дагуу шинэ үе шатны ажил эхлэх, дуусах тухай бүрт ажлын талбайд ажиллаж, ажлын гүйцэтгэл, ил далд ажлын актыг баталгаажуулж, гүйцэтгэгчтэй уулзах уулзалтын тэмдэглэлийг үйлдэж, уг тэмдэглэлийн хувийг уулзалтад оролцсон хүмүүст болон захиалагчид хүргүүлнэ. Хийгдэх арга хэмжээнд талуудын хүлээх үүрэг хариуцлагыг төслийн менежер уг ажлын уулзалтан дээр, эсхүл түүний

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 


	дараа шийдвэрлэж, энэ тухай ажлын уулзалтад оролцсон бүх этгээдэд зааварчилгаа өгөх мэдэгдлийг хүргүүлнэ.
ГЕН 32.0	Ажлыг ашиглалтанд хүлээн авсан өдрөөс хойш барилга байгууламжийн зүгшрүүлэх тохируулах чанарын баталгааны хугацаа [365] ³ хоног байна. Гүйцэтгэгч зөрчил гологдол арилгах мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш чанаргүй гүйцэтгэлтэй холбоотой эвдрэл гэмтэл, согогыг арилгаж дуусах өдөр хүртэлх хугацаагаар, эсхүл чанаргүй гүйцэтгэл, зөрчил гологдлыг арилгаагүй хугацаагаар чанарын баталгааны хугацааг захиалагч сунгана.
ГЕН 34.0	Гүйцэтгэгч ажлын үе шатны хуваарийг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан журмын хавсралт маягтын дагуу боловсруулж гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг авснаас хойш ажлын 10 хоногт багтаан Төслийн менежер ирүүлж батлуулна. Гүйцэтгэгч ажлыг үе шатны ажлын хуваарьт заасан хугацаанаас хоцроон гүйцэтгэсэн тохиолдолд үе шатны ажлын тодотгосон хуваарийг 10 хоногийн дотор гаргаж төслийн менежерээр батлуулна.
ГЕН 35.0	Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт, өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь ажлын тоо хэмжээ, үнийг өөрчлөхгүй.
ГЕН 40.0	Төлбөр хийх хугацаа нь төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш [30] ⁴ хоног байна.
ГЕН 41.0	Дараах тохиолдол нь мөн нөхөн төлбөр хийх нөхцөлд тооцогдоно: (а) захиалагч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлын талбайг ашиглуулах хугацаанд багтаж ажлын талбайн аль нэг хэсгийг ашиглах боломжийг гүйцэтгэгчид олгоогүй; (б) захиалагч бусад гүйцэтгэгчдийн хуваарьт гүйцэтгэгчийн гэрээний дагуу хийх ажилд нөлөөлөхөөр нэмэлт өөрчлөлт оруулсан; (в) захиалагчийн хүлээх эрсдэл нь гүйцэтгэгчид нөлөөлсөн; (г) захиалагчийн үйл ажиллагааны улмаас бий болсон урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдлыг арилгах, аюулгүй байдлыг хангах, эсхүл бусад үндэслэлээр шаардагдсан нэмэлт ажил гүйцэтгэх зааварчилгааг төслийн менежер өгсөн; (д) бусад гүйцэтгэгч, засаг захиргааны байгууллага, нийтийн үйлчилгээний газар, эсхүл захиалагч нь гэрээнд заасан хугацаа, бусад нөхцөлийг баримтлаагүйн улмаас гүйцэтгэгч нь хугацаа алдсан, эсхүл нэмэлт зардал гаргасан; (е) төслийн менежер ажлыг хойшлуулах шийдвэр гаргасан, эсхүл ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд шаардагдах зураг, техникийн тодорхойлолт, зааварчилгаа зэргийг гаргаж өгөөгүй; (ё) төслийн менежер нь ажлын далд хэсгийг нээх, эсхүл нэмэлт шалгалт туршилт явуулах зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн ба үүгээр зөрчил, гологдол илрээгүй бол; (ж) төслийн менежер нь ажил дууссан тухай мэдэгдлийг үндэслэлгүйгээр хугацаа хоцроож гаргасан;
ГЕН 41.1	Урьдчилан анхааруулаагүй, эсхүл төслийн менежертэй хамтран ажиллаагүйн улмаас захиалагчийн сонирхол хөндөгдсөн бол гүйцэтгэгчид нөхөн төлбөр төлөхгүй.
ГЕН 44.0	Гэрээний ерөнхий нөхцөлийн 44 дүгээр зүйлийн дагуу гэрээнд үнийн тохируулга хийж “ болохгүй ” Итгэлцүүртэй холбоотой дор дурдсан мэдээллийг “ хэрэглэхгүй ”
ГЕН 44.0	Дотоод болон гадаад валютаас бусад ⁵ валютын индекс “ хэрэглэхгүй ” байна.
ГЕН 45.0	Чанарын баталгааны барьцаа хөрөнгийн хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна.
ГЕН 46.0	Гүйцэтгэгч ажил дуусахаар төлөвлөсөн өдрөөс хойш хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг ⁷ захиалагчид төлөх ба алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй. Энэхүү алданги нь үе шатны ажлын хуваарьт заасан ажил гүйцэтгэх хугацаанд нэгэн адил хамаарна. Гүйцэтгэгчид олгох санхүүжилтийн дүнг алдангийн хэмжээгээр бууруулан олгоно.
ГЕН 46.0	Гүйцэтгэгчид олгох санхүүжилтийг хугацаа хоцроосон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчаас гүйцэтгэгчид төлөх бөгөөд алдангийн

3 Энэ хугацааг ихэвчлэн Иргэний хуульд нийцүүлж авна.

4 Энэ хугацаа 3 сараас илүүгүй байна.

31 Эдгээр индексийг гүйцэтгэгч санал болгох ба захиалагч хүлээн зөвшөөрсөн байна.

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



	нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй. Гүйцэтгэгчид алданги төлөх тохиолдолд гэрээний төлбөрийг алдангийн хэмжээгээр нэмэгдүүлнэ. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүжилт саатснаас үүсэх алдангийг захиалагч хариуцахгүй.
ГЕН 47.0	Урамшуулал олгох хэмжээ нь хоногт гэрээний үнийн 0 хувь байна. ⁶
ГЕН 48.0	Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргасан тохиолдолд олгох урьдчилгаа төлбөрийн дүн нь [мөнгөн дүн] байх ба гүйцэтгэгчид [огноо]-оос өмнө төлнө.
ГЕН 49.0	Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний үнийн 5 хувьтай тэнцүү дүнтэй байна. Гүйцэтгэлийн баталгаа нь тендерийн баримт бичгийн 7 дугаар бүлэгт заасан маягтын дагуу байна.
ГЕН 51.0	Ажил эхэлсэн өдрөөс чанарын баталгаат хугацаа дуусах хүртэл буюу “Барилгын тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.6 дахь хэсэгт заасан хугацаанд гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас, эсхүл дутуу орхисноос үүдэн барилга, байгууламж, хийц бүтээц, засал, тоног төхөөрөмжид гарсан алдагдал, эвдрэл, гэмтэл, чанаргүй гүйцэтгэлийг гүйцэтгэгч өөрийн зардлаар засварлана.
ГЕН 53.0	Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш 14 хоногийн дотор захиалагч ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
ГЕН 55.1	Гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан актыг тухайн үе шатны ажил дуусан өдрөөс хойш [огноо]-ны дотор гаргаж өгнө. Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [огноо]-ны дотор гаргаж өгнө. Ил далд ажлын акт, технологийн тоног төхөөрөмжийн туршилтын актыг тухайн чиглэлийн инженерийн хангамжийн байгууллагын төслийн баг дахь төлөөлөл, зохиогч тус тус баталгаажуулж, төслийн менежерт тайлагнана.
ГЕН 55.2	Хэрэв гүйцэтгэгч 55.1-д заасан баримт бичгийг гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс гэрээний үнийн 5 хувьтай тэнцэх хэсгийг төслийн менежер суутгана.
ГЕН 56.1	Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээний ерөнхий нөхцлийн 56.2 дахь хэсэгт заасан ноцтой зөрчил болон дор дурьдсан ноцтой зөрчлийг гаргасан гэж үзвэл гэрээг үл маргах журмаар цуцлах эрхтэй. Үүнд: 1. Барилга, байгууламжийн ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй буюу ажилд стандарт, захиалагчийн техникийн тодорхойлолтод зааснаас өөр чанаргүй материал бүтээцийг ашигласан, стандарт, норм ба дүрэм захиалагчийн техникийн тодорхойлолтыг хангаагүй тоног төхөөрөмж, бараа, материалыг нийлүүлсэн нь эрх бүхий этгээдийн дүгнэлтээр тогтоогдсон бол Иргэний хуулийн 355 дугаар зүйлийг үндэслэн захиалагч гэрээг цуцлана. 2. Үе шатны ажлын хуваарьт заасан ажлыг удаа дараа 5-аас дээш хоногоор хугацаа хоцроон гүйцэтгэсэн, ил далд ажлын болон технологийн тоног төхөөрөмж, шугам сүлжээний туршилтын актыг төслийн менежрээр батлуулаагүй, нөхөн бүрдүүлсэн нь тогтоогдсон 3. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч болон хяналт шалгалтын байгууллага, төслийн менежерээс өгсөн албан шаардлага, дүгнэлт, үүрэг даалгаварыг удаа дараа хэрэгжүүлээгүй. 4. Зураг, төсөл, техникийн нөхцлийг мөрдөөгүй 5. Гэрээний хугацаа дуусгавар болсон 6. Гүйцэтгэгч санхүүжилтээр олгосон гэрээний төлбөрийг зориулалт бусаар зарцуулах эрхгүй бөгөөд гэрээний төлбөрийн санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан нь тогтоогдсон 7. Ажлыг тендерт санал болгоогүй туслан гүйцэтгэгч, түншлэгч, бусад этгээдээр гүйцэтгүүлсэн нь эрх бүхий байгууллагаас тогтоосон
ГЕН 57.0	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 0-иар тооцно.

32 Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана. Шаардлагагүй бол “0” гэж бичнэ. 33 Ажлыг хэсэгчлэн дуусгах болон хэсэг бүрийн урамшууллыг зөвшөөрсөн бол энд тусгана.

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



ХОЁР. ЗАХИАЛАГЧ (ТӨСЛИЙН БАГИЙН)-ИЙН ЭРХ ҮҮРЭГ

2.1 Захиалагч нь “Барилгын тухай” хуулийн 37 дугаар зүйл, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1 дэх хэсгүүдэд заасан үүрэг болон Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлнэ.

2.2 Барилга байгууламжийн үндсэн ажилд хэрэглэсэн материал, бүтээцийн чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг итгэмжлэгдсэн лабораторид нууцалсан дугаар бүхий дээж өгч тодорхойлуулах, материалын гарал үүсэл, тохиролын гэрчилгээг хянах замаар үнэлэлт дүгнэлт гаргах, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, барилгын ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн актуудыг баталгаажуулах:

2.3 Барилгын үйл ажиллагаанд холбогдох барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж, холбогдох зардлыг хариуцах,

2.4 Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гарсан хохиролыг хариуцах,

2.5 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг батлагдсан зураг төсөл, норм, дүрэм техникийн нөхцөлийг зөрчиж, чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн, чанарын шаардлага хангахгүй материал бүтээцийг ашигласан Мэргэжлийн хяналтын болон эрх бүхий байгууллагаас хийсэн үзлэг, шалгалтын дүн, техникийн дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчил гологдлыг арилгаагүй тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн зардлаар засуулах, нөхөн хийлгэх, санхүүжилтийг зогсоох, учирсан хохирлыг төлүүлэх, гэрээг цуцлах

2.6 Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг дүгнэх, барилга, байгууламж, ажил үйлчилгээг ашиглалтад хүлээн авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах.

2.7 Чанарын баталгааны хугацаанд тухайн бараа, ажил, үйлчилгээнд зөрчил, гологдол, эвдрэл гараагүй болон зөрчил гологдлыг арилгасан тухай захиалагчийн томилсон ажлын хэсгийн дүгнэлт, захиалагчийн мэдэгдлийг үндэслэн барьцаа хөрөнгийг чөлөөлж, гүйцэтгэгчид олгох.

2.8 Төслийн менежер нь ажил худалдан авах гэрээний хэрэгжилтийн явцын талаарх дараах мэдээллийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт улирал бүрийн дараа сарын 01-ний өдөрт багтаан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

- гэрээний тусгай нөхцөлд дурдсан голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчний мэдээлэл

- Ажил худалдан авах гэрээний хэрэгжилтийн явц, үр дүн, гэрээ дүгнэсэн акт

- Ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг, үе шатны ажлын гүйцэтгэл

- Барилгад ашигласан материал, хийц, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, дүгнэлт, гарал үүслийн гэрчилгээ

- Барилгын талбайд ажиллаж байгаа инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдын судалгаа

- Зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлт,

- Барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг төсөл

- Захиалагчийн барилга техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт


- Тоног төхөөрөмж угсарсан актууд, холбогдох байгууллагаар баталгаажуулсан тоног төхөөрөмжийн туршилтын баримт бичиг, туршилт тохируулгын акт


- Санхүүжилтийн талаарх мэдээлэл

- Бусад шаардлагатай мэдээлэл

2.9 Тендерт өгөгдсөн ажлын тоо хэмжээ, захиалагчийн зөвшөөрсөн ажлын тоо хэмжээнээс гадна нэмэлтээр хийсэн ажлыг санхүүжүүлэхгүй.

2.10 Захиалагчийн санхүүжилтээр олгогдсон хөрөнгийг өөр зориулалтаар ашиглах, барилга угсралтын ажлын зураг төсвийг зохиогчийн дүгнэлт, захиалагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөн гүйцэтгэх, гэрээний нөхцөл, төсөв, норм дүрмийг зөрчиж ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэх, гарал үүсэл, тохиролын гэрчилгээгүй материал, хийц бүтээцийг ашигласан, мэргэжлийн байгууллагуудын зүгээс

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 

тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд захиалагч санхүүжилтийг зогсоох, гүйцэтгэгчээс татгалзах, гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах хүртэлх арга хэмжээг авч, учирсан хохирлыг төлүүлэх эрх эдэлнэ.

2.11 Төслийн менежер нь барилгын ажил дууссны дараа ашиглагч, гүйцэтгэгч, зохиогч, зөвлөхийг тус тус оролцуулан тухайн барилга байгууламжид үзлэг шалгалт хийж, захиалагчийн техник хяналтын нэгдсэн дүгнэлт гарган, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлтийн хамт аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хүргүүлнэ.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Гүйцэтгэгч нь “Барилгын тухай” хуулийн 40 дүгээр зүйл, Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1 дэх хэсгүүдэд заасан үүргийг хэрэгжүүлж, барилгын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажил эхлэх зөвшөөрөл авах, барилгын ажлын талбайд гал, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны горимыг мөрдөх, хөдөлмөр хамгааллын дэглэмийг сахиулах, гуравдагч этгээдийг барилгын ажлаас шалтгаалсан болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, байгаль орчин, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, ажлын явцад эвдэлсэн зам талбай, ногоон байгууламжийг нөхөн сэргээх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2 Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд дурдсан голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчнийг, эсхүл төслийн багаас зөвшөөрсөн бусад ажиллах хүчнийг ажиллуулна. Тендерт ирүүлсэн голлох мэргэжилтний хуваарьт заасан ажиллах хүчнийг өөрчлөх шаардлага гарвал энэ тухай хүсэлтийг төслийн багт гаргаж шийдвэрлүүлнэ.

3.3 Барилгын ажлыг магадлал хийгдсэн, баталгаажсан зураг төсөл, норм нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих, ил далд ажлын акт, үе шатны ажлын тэмдэглэл, үе шатны ажлыг гэрээнд заасан хугацаанд багтаан гүйцэтгэж, гүйцэтгэлийг захиалагчаар батлуулах, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, ажлын явцад илэрсэн гологдол, зөрчлийг тухай бүрт нь арилгаж, буруу, дутуу хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр нөхөн гүйцэтгэх, барилгын ажлын гүйцэтгэлийн баримт бичиг, архивыг хууль журмын дагуу бүрдүүлж захиалагч болон Төрийн архивт хүлээлгэн өгөх зэрэг чиг үүргийг гүйцэтгэгч хүлээнэ.

3.4 Далд ажлын актыг тухайн ажлыг хийж дуусмагц захиалагчийн хяналтын мэргэжлийн инженерт газар дээр нь тухай бүр үзүүлж батлуулах

3.5 Барилгын ажил ашиглагдаж байгаа материал, бүтээцийн лабораторийн шинжилгээ, сертификат, тохиролын гэрчилгээг барилгын талбайд байлгах, угсралт, суурилуулалтад оруулахаас өмнө захиалагчаар хянуулж, холбогдох зөвшөөрлийг авсан байна.

3.6 Гүйцэтгэгч компаний товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний нэр, гэрээний үнийн дүн санхүүжилтийн хуваарь, ажил, эхлэх, дуусах хугацаа бүхий мэдээллийн самбарыг тухайн объектийн байрлах газарт олон нийтэд үзэгдэхүйцээр уг ажил, үйлчилгээний чанарын баталгаат хугацааны туршид заавал байршуулна.

3.7 Барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн тохиолдолд гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж захиалагч, зохиогчоор батлуулах


3.8 Гүйцэтгэгч нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд ажлын байргүй, бага орлоготой өрх иргэнээс тодорхой хэсгийг ажлын байртай болгохыг эрмэлзэж, ажлын байртай болгосон иргэдийн судалгаа, тэндэнд олгосон цалин хөлсний мэдээллийг захиалагчид ирүүлнэ.

3.9 Барилга, байгууламж, ажил, үйлчилгээг ашиглалтанд хүлээн авах, болон туршилт тохируулга хийсэн тухай акт зэрэг баримт бичиг албан ёсоор баталгаажаагүй, барилга байгууламжийн ашиглалтад хүлээн авах тухай шийдвэргараагүй байх хугацаан дахь тухайн барилга, байгууламжийн ашиглалт үйлчилгээтэй холбоотой урсгал зардлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна.

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



ДӨРӨВ. АЖИЛ, МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ ХИЙЦИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ


№	Бараа материал бүтээц хийцийн нэр	х/н	тоо	Нийт үнэ	тавигдах шаардлага стандарт	Нийлүүлэгч
1	45 хүртлэх хүүхдийн багтаамжтай олон үйлдэдтэй комплекс тоглоом	ком	1	25 000 000	Хэмжээ: 1050*860*490 Багтаамж: 15-45 хүүхэд Насны хязгаар: 2-5 нас Материал: Сайжируулсан хувинцар, цайрдсан төмөр	БНХАУ 4131053
2	Гэдэс таталтын дасгалын төхөөрөмж	ш	1	420 000	Хэмжээ 70*50*150см Материал: Сайн чанарын цайрдсан төмөр	БНХАУ
3	Хөл савалтын дасгалын төхөөрөмж	ш	1	750 000	Хэмжээ: 115*42*130см Материал: Сайн чанарын цайрдсан төмөр	БНХАУ
4	Гүйлтийн зам дасгалын төхөөрөмж	ш	1	1 000 000	Хэмжээ: 110*50*145см Материал: Сайн чанарын цайрдсан төмөр	БНХАУ
5	Гар эргүүлдэг сунгалтын дасгалын төхөөрөмж	ш	1	750 000	Хэмжээ: 112*80*115см Материал: Сайн чанарын цайрдсан төмөр	БНХАУ
6	Цээж бэлхүүсний дасгалын төхөөрөмж	ш	1	750 000	Хэмжээ: 110*110*130см Материал: Сайн чанарын цайрдсан төмөр	БНХАУ
7	Түшлэгтэй хогийн сав	ш	4	1 320 000	Хэмжээ: 150*60*80см Материал: Сайн чанарын цайрдсан төмөр	БНХАУ
8	Ангилдаг хогийн сав	ш	2	600 000	Хэмжээ: 60*35*90см Материал: Сайн чанарын цайрдсан төмөр	БНХАУ

ТАВ: АЖЛЫН ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ


Хөвсгөл аймаг, Мөрөн сум. Хүүхдийн паркийн тохижилт болон тоног төхөөрөмж нийлүүлэх
Багц 9 ажил

№	хийгдэх ажил	сар	6 сар		дүн
		10 хоног	1	2	
1	Тоглоомын талбайн суурь бэлтгэх ажил	төлөвлөгөө	18,116,104		18,116,104
		гүйцэтгэл			
2	Тоног төхөөрөмжийг нийлүүлж, угсарч суурилуулах	төлөвлөгөө		30,590,000	30,590,000
		гүйцэтгэл			
3	Захиалагчийн хяналтын зардал	төлөвлөгөө	328,846		328,846
		гүйцэтгэл			
4	Зохиогчийн хяналтын зардал	төлөвлөгөө	164,423		164,423
		гүйцэтгэл			
5	Магадлашгүй ажил	төлөвлөгөө	328,846		328,846
		гүйцэтгэл			
6	Инженер хайгуул, зураг төсвийн үнэ				
7	Улсын комисст хүлээлгэн өгөх	төлөвлөгөө			49,528,219
		гүйцэтгэл			

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



Санхүүжилтын хуваарийг доорх хүснэгтээр гаргав.

Санхүүжилтийн хувиарын доторх гүйцэтгэл

Д/Д	Ажлын нэр	Гэрээний дүн /төгрөгөөр/	2020 он		ДҮН
			06 сар	07 сар	
1	Тоглоомын талбайн суурь бэлтгэх ажил	49 528 219	18,116,104		18,116,104
2	Тоног төхөөрөмжийг нийлүүлэж, угсарч суурилуулах		30,590,000		30,590,000
3	Захиалагчийн хяналтын зардал		328,846		328,846
4	Зохиогчийн хяналтын зардал		164,423		164,423
5	Магадлашгүй ажил		328,846		328,846
Ажлын гүйцэтгэл /хувиар/			100%	0,0%	49,528,219
Санхүүжилтийн дүн /хувиар/			100%	0,0%	49,528,219
Санал болгож буй санхүүжилтийн дүн					

ЗУРГАА: БАРИЛГЫН АЖИЛД АШИГЛАХ МОНГОЛ УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ГАРАЛ ҮҮСЭЛТЭЙ БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ ХИЙЦИЙН ЖАГСААЛТ

№	Бараа материал бүтээц хийцийн нэр	х/н	тоо	Нийт үнэ	тавигдах шаардлага стандарт	Нийлүүлэгч
	байхгүй					

**ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА,
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР

 **Б.БОЛД**

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын байр
Утасны дугаар: 99034867

6715-251-1 4131053


**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

“УРГАМАЛЫН ДАЛАЙ”ХХК-
ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


 **Б.БАТСАЙХАН**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
9-р хороо, Хоймор оффис 12давхар
1208 тоот
Утас: 70110085, 95955585
Харилцагч банкны нэр:
Голомтбанк
Дансны дугаар: 1105065510
Регистрийн дугаар: 5340055

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ



- | | |
|--|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |

Захиалагчийг төлөөлж:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

9. Зөрчил,
гологдол
арилгах

9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа⁷ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

10. Зөрчил,
гологдол
арилгахгүй
байх

10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Үе шатны
ажлын хуваарь

11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.

11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.

12. Үе шатны
ажлын
хуваарийг
өөрчлөх

12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

13. Алданги

13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги⁸ төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. Ажил дуусгах

14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежер тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.


15. Хүлээж авах

15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч

⁷ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

⁸ Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

16. Эцсийн
тооцоо

16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.

Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Ашиглалт,
засвар,
үйлчилгээний
гарын авлага

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;


(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг
цуцалсан үед
хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.


20. Гүйцэтгэлээс
чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТӨСЛИЙН МЕНЕЖЕРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

 Ц.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын байр
Утасны дугаар: 99035647


ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“УРГАМАЛЫН ДАЛАЙ”ХХК-
ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

 Б.БАТСАЙХАН

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
9-р хороо, Хоймор оффис 12 давхар
1208 тоот
Утас: 70110085, 95955585

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:

